

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРОО

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

**2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг**

|                                                                                                          |         |
|----------------------------------------------------------------------------------------------------------|---------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>                                                                   | 1       |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>                                                                        | 2 – 4   |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>                                                                 | 5 – 16  |
| <br>                                                                                                     |         |
| <i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/</i>                             | 6 – 10  |
| <br>                                                                                                     |         |
| <i>2. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэх</i> | 10 – 16 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
05 дугаар сарын 07-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 11 гишүүн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 14 минутад “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: О.Саранчулуун;  
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдааны эхэнд хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат “Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хойшуулъя гэсэн горимын санал гаргав.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

***Нэг. Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын

албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ч.Ундрам Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Г.Хосбаяр нар санал хэлэв.

**Ч.Ундрам:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Галбадрах нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт Д.Отгон, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарангэрэл, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням тайланг хэлэлцэх асуудлыг хойшуулъя гэсэн горимын санал гаргав.

**Ч.Ундрэм:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням гаргасан горимын саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм үг хэлэв.

*Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 29 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 86.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 43 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ч.УНДРАМ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
14 цаг 14 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ч.Ундрам:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ирвэл зохих 15 гишүүнээс. Ирцдээ орсон уу? М.Сарнай гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн орсон уу? С.Эрдэнэбат гишүүн ирцдээ орсон уу?

15 гишүүнээс 11 гишүүн ирсэн учраас хуралдааныг эхлүүлье. /алх цохив/

Ирцийг хүснэгтээр танилцуулъя. О.Батнайрамдал гишүүн ирсэн байна, Д.Бум-Очир гишүүн ирсэн, Ш.Бямбасүрэн гишүүн ирсэн, Ж.Галбадрах гишүүн ирсэн байна, Ц.Мөнхтуяа гишүүн ирсэн, Д.Рэгдэл гишүүн ирсэн, М.Сарнай гишүүн ирсэн, Ч.Ундрам ирсэн, Г.Хосбаяр гишүүн ирсэн, Б.Хэрлэн гишүүн ирсэн, С.Эрдэнэбат гишүүн ирсэн. Ийм ирцтэй байна.

Хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

**Нэг.** “Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл батлах.

**Хоёр.** Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэх.

**Гурав.** Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ гэсэн ийм гурав асуудал байна. Энэ дээр саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудал дээр. Д.Рэгдэл гишүүн саналаа хэлье.

**Д.Рэгдэл:** Энэ хэлэлцэх асуудлынхаа дараа л жаахан өөрчлөлт оруулмаар байгаа санагдаад байгаа юм. Бас сүүл рүү нэг ажил давхцаад цаг нь тулчихвал, бас гараад явбал тогтоол батлах юм ороод байгаа.

Тийм учраас “Чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл байна шүү дээ. Байнгын хороо. Үүнийг хоёрдугаарт нь оруулвал болох уу гэсэн ийм л санал байгаа юм.

**Ч.Ундрам:** Энэ хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах асуудлаар санал өгөх юм байна.

Мөн Г.Дамдинням гишүүн энэ нэгдүгээр асуудалдтай холбоотой ажлын хэсгийн ахлагч нь юм. Тэгээд өөрөө нэгдүгээрт “Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэхгүй, өөр өдөр түр хойшлуулъя, өөр өдөр хэлэлцүүлэхээр саналаа оруулъя гэсэн юм.

Тэгэхээр ийм хоёр санал энэ хэлэлцэх асуудал дээр байгаа. Тэгэхээр тус тусад нь санал хураалгах уу? Тэгэхээр эхлээд Д.Рэгдэл гишүүний гаргасан хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах гээд. Энэ Байнгын хорооны тогтоолын төслийг хамгийн түрүүнд хэлэлцэх гэдэг ийм байдлаар санал хураалт явуулъя.

Хэлэлцэх асуудал дээр С.Эрдэнэбат гишүүн бас нэг саналтай байгаа. Тийм ээ.

Саяын санал хураалтаар 11 гишүүнээс 7 гишүүн зөвшөөрч, 63.6 хувиар зөвшөөрлөө.

С.Эрдэнэбат гишүүн саналаа хэлье.

**С.Эрдэнэбат:** Г.Дамдинням гишүүний байгуулсан ажлын хэсгийг оруулах асуудлыг түр хойшлуулах саналыг гаргаж байна. Тийм. Ажлын хэсгийн гишүүний хувьд.

**Ч.Ундрэм:** Ажлын хэсгийн гишүүн С.Эрдэнэбат гишүүн энэ нэгдүгээр асуудлыг хойшлуулъя гэсэн санал оруулж байна. Үүнийг дэмжье гэсэн байдлаар санал хураалт явуулъя. /алх цохив/

11 гишүүнээс 8 гишүүн зөвшөөрч, энэ нэгдүгээр асуудлыг хойшлууллаа.

Тэгэхээр саяын санал хураалтад үндэслээд Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ. Гуравдугаар асуудал.

---

### **Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл**

/Засгийн газарт чиглэл өгөх тухай/

---

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүд байна уу? Байхгүй юу. Тийм ээ. Асуулт, санал тасаллаа. Үг авах уу?

Тогтоолын зүйл заалт дээр үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүдийг Г.Хосбаяр гишүүнээр тасаллаа. Д.Рэгдэл гишүүн үг хэлье.

**Д.Рэгдэл:** “Чиглэл чиглэл өгөх тухай” тогтоолыг батлахыг дэмжиж байгаа.

---

Тэгээд дотор талд нь аваад үзэхээр найруулгын чанартай ч юм уу, бас тэр нь буруу ойлгогдох агуулгын чанартай асуудлууд байгаад байна уу гэж харж байгаа.

1 дүгээр заалт дээр ерөнхийдөө найруулгын чанартай жижигхэн өөрчлөлт оруулъя гэсэн ийм саналыг энэ дээр тэмдэглэсэн байж байгаа.

Энэ нь юу байна вэ гэхээр энэ хуучин, анхны төсөл дээр бичсэн заалт дээр жоохон ийм өөрчлөлт оруулъя гэсэн санал байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1-д заасан “зорилтын хэрэгжилтийг хангуулах болон” гэж оруулмаар байгаа юм. “Мөн” гэдгийг нь дараад.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор байгуулсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажилд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хяналт шалгалтын үр дүнг үндэслэн гээд шууд явмаар байгаа. Хяналт шалгалтын үр дүнг үндэслэн дараа арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай гээд хоёр газарт нь заалт оруулъя гэж бодож байгаа.

Дараа нь, 1.1 дүгээр хэсэг. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар. Энд найруулгын чанартай хоёр жижиг юм байгаа. Үүнийг нэг их яриад, хэлээд байх онцын ач холбогдол багатай заалтууд. Тэгэхдээ агуулга нь зөв гаргахын тулд 1.1-ийг бол жишээлбэл ариун цэврийн байгууламж, ашиглалтын тогтмол зардлыг холбогдох төсөвт тусган, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр болгох. Үүнийг заавал орон нутгийн төсөвт тусгаад байх шаардлагагүй. Холбогдох төсөвт. Байгууллагын төсөвт нь тусгаж өгч болно гэж бодоод байгаа юм.

1.3 бол тог, цахилгаан гээд бичээд байгаа юм. “Тог” гэдэг чинь угаасаа орос үг л дээ. Тийм ээ.

Тэгэхээр бид үүнийгээ сайхан монгол үгээр. Цахилгаан эрчим хүчний хэлбэлзэлтэй сум гэдэг юм уу, яадаг юм. Тэгж засах нь зүйтэй. Тог гэж оросоор нь бичье гэвэл “Г” үсгийг нь “К” болгож засах ёстой шүү.

Авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар энэ 2 дахь заалт байгаа юм. 2.1 дээр хамгийн төгсгөлд нь нэг заалт нэмж оруулмаар байгаа. Яагаад вэ гэдгийг нь би товч тайлбарлана.

Хамгийн төгсгөлд нь “тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангах”. Таслал тавьчихаад юу нэмэх вэ гэхээр “улмаар бүх сумыг цэвэр, бохир ус, дулаан хангамжийн төвлөрсөн системтэй болгох шат дараалсан арга хэмжээ



авч хэрэгжүүлэх” гэмээр байгаа юм. Яагаад гэвэл одоо бид чинь энэ бүх сумдыг төвлөрсөн ийм системтэй болгох ажлаа хийж эхлэхгүй бол сум болгоныг аймгийн төвтэй холбоно гээд асар их хөрөнгө оруулалттай, явц багатай, хоёрдугаар ээлжийн зорилтоо нэгд тавьчихаад байгаа.

Тэгэхээр сум болгоныг аймгийн төвтэй авто замаар холбохынхоо өмнө талд нь ариун цэвэр, бохир ус, дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгох нь нийгмийн ач холбогдлын хувьд илүү юм байна гэсэн ийм утга учиртай байгаа юм.

Ингээд 2.2-оос эхлээд явж байгаа. Энд нэг жаахан хоёрдмол ойлголт яваад байгаа. Орон нутагт хэрэгжүүлж буй ариун цэврийн байгууламж барих төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад тогтмол хяналт болгох гээд л “ариун цэврийн байгууламж” гээд яваад байгаа.

Тэгэхээр энэ “ариун цэврийн байгууламж” маань энэ 2.6 хүртэл явж байгаа. 2.2-оос. Энэ маань нөгөө сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж гэдгийг тодотгоод заамаар байгаа юм. Тэгэхгүй бол 2.1 дээр нөгөө “ариун цэврийн байгууламж” яваад байгаа шүү дээ. “Шинэ сум” хөтөлбөрийн хүрээнд “ариун цэврийн байгууламж” гэсэн. Тэр нь явж байгаа юм шиг ойлголт ороод байна.

Тэгэхээр энэ дээр нь тодотгол хийгээд л өгчихвөл.../минут дуусав/

**Ч.Ундрам:** Болсон уу? Тийм ээ. Саяын редакцын засваруудыг манай Байнгын хорооны референтүүд тэмдэглэж аваарай.

Г.Хосбаяр гишүүн санал хэлье.

**Г.Хосбаяр:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ тогтоол дээр 100 хэдэн тэрбумаар хийсэн хөрөнгө оруулалтаа бид хаана бүртгэж барьж авах юм? Нөгөө сургуулиуд нь өмчлөлдөө байлгах юм уу? Эсвэл бид нарын яриад байгаа аймаг, орон нутагт байгаа мэргэжлийн байгууллага буюу нөгөө орон нутгийн өмчит компани байгаа шүү дээ. Тэдний өмч болох юм уу? Үүнийгээ бас нэг тодорхой зааж өгвөл яасан юм бэ гээд.

Тэгэхгүй бол манай өмч биш учраас бид ашиглалтыг нь хариуцахгүй ч гэдэг юм уу. Ингээд янз бүрийн асуудал бас яригдах вий.

Дээр нь цаашдаа засвар үйлчилгээ, тэр урсгал зардлыг нь улсын төсөвт л суулгаж өгөх байх даа. Салбарын яаман дээр. Тэгэхгүй бол аймгууд чинь төсөв мөнгө хүрэхгүй гээд л. Суулгахгүй бол тэгээд ашиглалтгүй л болно шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр би бол үүнийг яаманд нь тэр зардал юмаа хариуц гээд. Тэгээд тэр өмчлөлийг бас нэг чиглэл өгсөн нь дээр үү гэж бодож байна.

**Ч.Ундрэм:** Ерөнхийдөө өмчлөл, бүртгэлийн асуудал, мөн ашиглалтын зардал гэсэн асуудлуудыг бид ирэх жилийн төсөв орж ирнэ шүү дээ. Төсвийн цикл эхэлсэн байгаа.

Тэгэхээр Сангийн яам болон орон нутаг, боловсролын яамтайгаа зөвшилцөж байгаад яг үүнийг нь хэн нь өмчлөлийг нь хариуцах юм, ашиглалтын төсвийг нь хаана тавих юм гэдгийг нь нэлээн тодорхой болгоё.

Манай ажлын хэсгийн хувьд ажлын хэсгийн маань дуусаагүй ажил нь. Энэ болохоор хугацаатай үүрэг өгч байгаа юм.

Тэгэхээр дараа дараагийн Засгийн газарт чиглэл өгөх тогтоолууд бид гаргаж болно. Хуралдаж байгаад. Тэгээд сая манай ажлын хэсэг 4 аймгаар яваад ирсэн шүү дээ. Тийм ээ. Г.Хосбаяр гишүүн бас хамт явсан.

Тэгээд Хөвсгөлийн хязгаарт байгаа Дархадын хотгорын Улаан-Уул сум хүртэл яваад ирсэн байгаа. Хатгал бас орсон байгаа. Тэгээд тэнд байгаа нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан.

Тэгээд бид яалт ч үгүй яаралтай хугацаатай үүрэг бүхий тогтоолыг оруулж батлуулахгүй бол зуны дараа намар, тэгээд л өвөл болоход нөгөө цэвэршүүлсэн ус нь хөлдөх аюул байна. Мөн сумдад анх удаа дотор ариун цэврийн байгууламж баригдсан учраас тэнд сангийн асуудал мэддэг нэг ширхэг ч хүнгүй тийм сум бас байдаг юм байна.

Тэгэхээр энэ хүмүүсийг сургах, зарим сумдад дунд нь цэвэр бохирын усны машин авч өгөх гэх мэтчилэн яаралтай шийдэх ёстой асуудлууд байгаа учраас өнөөдөр ийм хугацаатай үүрэг бүхий тогтоолын төсөл оруулж ирж байгаа юм.

Тэгээд гишүүд маань санал хэлж дууслаа.

Тийм учраас саяын найруулгын саналуудыг аваад. Г.Хосбаяр гишүүний энэ саналыг бид жоохон судалж байгаад дараагийн тогтоолдоо оруулъя. Тэгэх үү. Д.Рэгдэл гишүүний найруулгын саналыг аваад тэгээд энэ тогтоолын төслөө баталъя гэсэн санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүнээс 10 гишүүн дэмжсэн.

Үүн дээр нэмээд Г.Дамдинням гишүүн бас протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье гээд. Ж.Галбадрах багш бас дэмжсэн байна.

Тэгээд ихэнх гишүүд дэмжсэн учраас тогтоолын төслийг баталсанд тооцлоо. /алх цохив/

---

**Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон  
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн  
тайлан хэлэлцэх**

---

Дараагийн асуудал байгаа. Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэх ийм асуудал байгаа.

Энэ асуудлыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулах юм байна.

Хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрс. Э.Одбаяр сайд дээр нэмээд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр ирсэн байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа ирээгүй байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав ирсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт Д.Отгон ирсэн байна.

Боловсролын сайд П.Наранбаяр ирсэн байна. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал ирсэн байна. Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир. Түрүүн харагдаад байсан. Энд алга. Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа ирсэн байна. Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарангэрэл ирсэн байна. Боловсролын яамны Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал ирсэн байна. Боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын дарга М.Цогзолмаа арай ирээгүй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг. Ирээгүй.

Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт ирсэн байна.

Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж ирсэн байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа орж ирээгүй байна. Энд ирчихсэн байна. Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх Б.Отгонсүрэн ирсэн байна. Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын референт Ц.Элбэгзаяа ирсэн байна.

Ийм бүрэлдэхүүн ирсэн байна.

---

Танилцуулгыг Э.Одбаяр сайд танилцуулах уу? 5 номерын микрофон.

**Э.Одбаяр:** Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж Засгийн газарт танилцуулах гэж заасныг тус тус үндэслэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Яам аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно.

Мөн Засгийн газрын 206 дугаар тогтоолын 8.5-д Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ажлын албанд тус тус хүргүүлнэ гэж заасны дагуу 2025 оны 02 сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газарт тайланг хүргүүлсэн.

Монгол Улсын хуульд Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим санд Монгол Улсын хуулийн 89, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын байнгын хорооны 79, нийт 272 шийдвэрийн 1550 заалт бүртгэлтэй байгаа бөгөөд хэрэгжилт нь дунджаар 66.4 хувьтай байна.

Энэ нь мөн оны өмнөх үеэс 3.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүнээс:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гаргасан 4 тогтоолын 25 заалтын хэрэгжилт дунджаар 67.9 хувь буюу “хэрэгжих шатандаа” гэж үнэлэгдсэн байна.

Тэгээд тус Байнгын хороотой холбоотой гаргасан тогтоол, шийдвэрийн талаарх дэлгэрэнгүй тайланг Та бүхэнд тараасан байгаа.

Тэгээд шийдвэрүүдийн талаарх үнэлгээг танилцуулъя.

2021 оны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай тогтоол гарсан.

Энэ тогтоолын 1.1-д нь Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай гээд

Нэгд нь, Биеийн тамир, спортын тухай хууль. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газар бүх шатын иргэдийн Хурал, аймаг, нийслэлийн Засаг дарга, Биеийн тамир, спортын улсын хороо хангаж ажиллах гэж заасан заалтыг

- ▶ 100 хувийн биелэлттэй 29 ажил,
- ▶ 70 хувийн биелэлттэй 2 ажил,
- ▶ 30 хувийн биелэлттэй 1,
- ▶ хэрэгжээгүй 4 ажил байна.

Нийтдээ дунджаар үнэлгээ нь 70 хувьтай гэж үнэлсэн байна.

15 яам, 21 аймаг энэ ажлын талаар тайлагнасан байна.

Биелэлтийнх нь тайланг товч хураангуйлж танилцуулбал тус заалтын хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Батлан хамгаалах яам, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Зам, тээврийн яам, Сангийн яам, Хот байгуулалт, орон сууцжуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Эрчим хүчний яам болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газраас тайлан ирүүлэхээс Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрчим хүчний яамнаас тайлан ирээгүй.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас хамааралгүй заалтын биелэлтийг тайлагнаж ирүүлсэн.

Бусад яам болон аймгуудад тус тусын заалтын хэрэгжилтийг хангасан байна гээд.

Ингээд дараагийн нэг заалт нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.12-т магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцдаг байсан зохицуулалтыг сэргээх асуудлыг судлах чиглэл өгөгдсөн байна.

Энэ дээр 2024 оны 6 дугаар сард баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга дахь хөдөлгөөний хомсдолоос шалтгаалсан халдварт бус өвчлөлийн эрсдэлийг бууруулах зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг харгалзан магадлан итгэмжлэгдсэн спорт клубт Спортыг дэмжих сангаас үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлж болохоор тусгасан гээд энэ заалтыг биелсэн гэж дүгнэсэн байна.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамир, спортын хичээлийн хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамрах, суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн байна.

16 арга хэмжээг биелсэн гэж үзээд 7 арга хэмжээг 70 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж байгаа гэж дүгнэсэн байна. Дунджаар 70 хувийн гүйцэтгэлтэй гэдэг үнэлгээ хийсэн байна.

Ингээд нийтдээ 4 тогтоолын 25 заалтын дундаж нь 67.9 хувьтай буюу хэрэгжих шатандаа гэж үнэлэгдсэн байна.

Эндээс биелэгдээгүй 1 заалт байгааг Та бүхэнд бас уншиж танилцуулъя.

Энэ тогтоолын хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр танилцуулахыг Засгийн газарт даалгасан байна.

Тус заалтын хэрэгжилтийг Боловсролын яам болон Эрүүл мэндийн яамнаас тайлагнасан байна. Ирүүлсэн тайлан нь хэт ерөнхий байдлаар хэмжигдэхүйц бус байна.

Тогтоолын хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд хүргүүлж тайлагнаагүй байна гэдэг дээр нь энэ заалтыг хэрэгжүүлээгүй гэж үзсэн. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс.

Тэгээд хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй шалтгаануудыг нь Улсын Их Хурлын тогтоол болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл болгосон шийдвэр гаргасан тухай бүрд хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхгүй байгаагаас зарим шийдвэрийг тухай бүр цахим хяналтын системд бүртгэж авах боломжгүй байдал байгаад байгааг бас шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Холбогдох байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулан үзэж, хүрсэн үр дүнг тайлагнаагүй, утга агуулгын хувьд алдаатай тайлагнах, өмнөх оны

хэрэгжилтийг хуулбарлан давтан тайлагнасан, өөрийн үнэлгээг бодитой үнэлээгүй зэрэг нийтлэг алдаа гаргасан байна.

Ер нь өнгөрсөн жилүүдэд Улсын Их Хуралд, тэр дундаа холбогдох Байнгын хороодод нь Засгийн газрын зүгээс хууль тогтоомжийн биелэлтийн тайланг хэлэлцүүлж байгаагүй юм билээ.

Тэгээд энэ удаагийн тайлан анхны удаагаа хэлэлцэгдэж байгаа учраас Байнгын хорооны гишүүдийнхээ санал шүүмжлэл, зөвлөмжийг авахад нээлттэй байгаа шүү гэдгээ хэлэх гэсэн юм.

Тэгээд анхаарлаа хандуулсанд баярлалаа. Асуулт байвал хариулъя.

**Ч.Ундрэм:** Сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Г.Дамдинням гишүүн горимын санал.

**Г.Дамдинням:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд сая өнөөдөр өглөө Төсвийн байнгын хороо энэ асуудлаар бас хуралдсан. Төрийн байгуулалтын байнгын хороо бас өмнөх долоо хоногт хуралдсан.

Тэгээд одоо энэ хамгийн сүүлийн хуудсан дээр Та бүхэн ингээд харахад нийтдээ 1200 орчим Улсын Их Хурлын шийдвэр гарсан байгаа юм.

Өөрөөр хэлбэл бидний ажлын ажил явсан гэсэн үг. Үүний 519-ийг нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар үнэлэх хэрэггүй гэсэн шийдвэр гаргасан байгаа байхгүй юу. Боломжгүй байна гэж.

Энэ чинь Их Хурал, Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага өөрөө бид нарын ажлыг ард түмэнд яваад очиход, бид ард түмний төлөөлөл гээд яваад очиход та нар хийсэн ажил чинь хаана байгаа юм бэ гэж нэхнэ. Нэхсэн ажлын маань хэрэгжилт, биелэлт нь ийм байдалтай байгаад байдаг.

Дээрээс нь гишүүдэд ерөөсөө өчигдөрхөн тараагаад л, одоо ингээд л хэлэлцэх гээд байдаг. Бидний хамгийн том чухал асуудал юун дээр явагдаад байгаа вэ, алдаа хаана яваад байгаа вэ гэхээр, төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын хамгийн том асуудал юун дээр яваад байгаа вэ гэхээр хууль батлах ажлаа бид хийгээд байна. Хуулийн хэрэгжилтийг шаардах, хангуулах ажил маань дутуу болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас бидний ажлын үр дүн сул болчихоод байгаа юм. Их Хурал ажлаа хийгээд байдаг. Засгийн газрын ажил дээр 64 хувьтай хэрэгжсэн байна гэдэг үнэлгээ өгчхөөд дийлэнх хэсгийг нь үнэлээгүй гэсэн. Одоо бараг тал орчим хувийг нь үнэлээгүй гэсэн ийм тайлан оруулж ирэх боломжгүй болчихоод байгаа байхгүй юу даа.



Тэгэхээр энэ асуудлыг өмнөх Байнгын хорооны хурлууд дээр ярилцаж байгаад ер нь Их Хурлын даргын захирамжаар ч юм уу, Ч.Ундрам дарга аа. Тийм ээ. Манай Байнгын хорооны дарга даргын дэргэдэх зөвлөл дээр Байнгын хорооны дарга нар санал нэг байна лээ. Даргын дэргэдэх зөвлөл дээр асуудал ярьж байгаад ажлын хэсэг гаргаад, энэ Хяналт хэрэгжүүлэх газрын гаргасан ажлыг хуулийг хэрэгжүүлэх. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын тогтоолууд, хуулиуд, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны гаргасан тогтоолууд, дэд хорооны тогтоолууд, түр хорооны тогтоолууд бүгд яригдах ёстой. Бүгд яг ижилхэн хуулийн үндэслэлтэй, суурьтай ийм ажлууд байхгүй юу. Бүгд ижилхэн хуулийн хүчин чадалтай юм.

Гэтэл энэ дэд хороо алга, түр хороо алга. Байнгын хорооны тогтоолын зүйл, заалт болгоноороо бид ярих ёстой.

Дөнгөж сая бид өнөөдөр манай Байнгын хорооны даргын маш их анхаарал тавьж ажилладаг боловсон нольтой холбоотой тогтоол гаргаж ирээд л хэрэгжиж өгөхгүй. Тийм ээ. Ингээд л араас нь дахин дахин тогтоол гаргаад яваад байдаг. Тийм.

Хэрэгжүүлэхгүй бол Их Хурал тогтоол гаргаад ямар ч хэрэггүй байгаа байхгүй юу. Бид нэг сонссон болоод л. Эд нар маань нэг танилцуулсан ингээд л өнгөрчхөж байгаа юм.

Тэгэхээр дарга аа, даргын дэргэдэх зөвлөл дээр та хэд маань нэг яриад, Байнгын хороо болгоны төлөөллийг нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй яам, яамдынх нь чиглэлээр нь гаргаад ингээд нэг Их Хурлын ажлын хэсэг энэ Хяналт шалгалтын газар луу ороод ингээд үүнийг дахиж нэг ултай суурьтайхан шиг нэлээн сайн ярьж байж хэлэлцье гэдэг ийм үндэслэлээр энэ асуудлыг хэлэлцэхийг хойшлуулах, түр хугацаанд хойшлуулах горимын санал гаргаж байгааг дэгийн тухай хуулийн дагуу хэлэлцэж, дэгийн тухай хуулийн дагуу санал хураалгаж өгнө үү.

**Ч.Ундрам:** Г.Дамдинням гишүүн горимын санал гаргалаа.

Тэгээд ер нь Их Хурлын гаргаж байгаа хууль, баталж байгаа хууль, гаргаж байгаа тогтоолыг хянадаг, мониторинг хийдэг байгууллагууд нэлээн байгаа. Үндэсний аудитын газар хамгийн том Их Хурлын аудит хийдэг ийм байгууллага байна. Одоо манай Засгийн газар бас дотроо энэ чиглэлийн сайдтай, яамтай болсон. Их Хурал дахь үнэлгээ, мониторингийн газар гээд байна.

Тэгэхээр ер нь 519 заалтыг хяналтын хяналт үнэлгээний цахим системээс хасна гэдэг чинь шууд ингээд л бөөндөөд хасчхаж болохгүй байх л даа. Өчнөөн бид чинь хуралдаж, хэлэлцэж, ажиллаж, тархи толгойгоо уралдуулж мэтгэлцэж байж энэ шийдвэр, заалтуудыг гаргасан байгаа шүү дээ.

Тэгэхээр миний хувьд ч гэсэн бас Г.Дамдинням гишүүнтэй санал нэг байна.



Тэгээд горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ асуудлыг тодорхой хугацаагаар хойшлуулах санал хураалт. Хугацаа нь тодорхойгүй хугацаагаар. Тийм. Түр хойшлуулах. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 84.6 хувь нь хойшлуулъя гэсэн асуудлыг дэмжлээ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан учраас хуралдааныг хаая. /алх цохив/

Хуралдаан 29 минут үргэлжилж, 14 цаг 43 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**